



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХ, ХҮН АМЫН ТАНИЛЦУУЛГА

2024



Улаанбаатар хот
2025 он

www.ubstat.mn




ХЯНАСАН:

Д.Мөнхзул

ЧД-ийн Статистикийн хэлтсийн дарга

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

Г.Пүрэвсүрэн

ЧД-ийн Статистикийн хэлтсийн ахлах
мэргэжилтэн

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРЭГ, САМБУУГИЙН ГУДАМЖ
ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
БАЙР, 401 тоот

Утас: 70113013

70130767

70110767

976-11-310767

51-261125

Цахим хуудас: www.ubstat.mn
www.chingeltei.gov.mn

И-мэйл: chingeltei@nso.mn

ХҮН АМ

Энэ бүлэгт дүүргийн хүн амын өсөлт, нас хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт зэрэг хүн амын ердийн хөдөлгөөний статистикийн үзүүлэлтийг тусгав.

Хүн амын статистик мэдээллийн үндсэн эх үүсвэр нь хүн ам, орон сууцны ээлжит болон 5 жил тутамд явагдаг завсрын тооллого, хүн амын ердийн шилжих хөдөлгөөний жил бүрийн мэдээ тайлан болно.

Монгол Улсын хүн амд Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа болон гадаадад 6, түүнээс дээш сарын хугацаагаар оршин суугаа Монгол Улсын харьяат хүн амыг хамруулна.

Өрх гэж нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг бүлэг хүмүүсийг ойлгоно. Өрхийн гишүүд нь

хоорондоо ураг төрлийн болон гэр бүлийн хамааралтай эсвэл хамааралгүй байж болно.

Өрх толгойлсон эмэгтэйчүүдэд өрх толгойлон амьдарч байгаа эмэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.

Төрөлтийн хүйсийн харьцаа нь төрсөн эрэгтэй хүүхдийн тоог төрсөн эмэгтэй хүүхдийн тоонд харьцуулсан харьцаа юм. Төрөлтийн ерөнхий коэффициент нь 1000 хүнд ногдох тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоог хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, илэрхийлнэ.

Төрөлтийн тусгай коэффициент нь нөхөн үржихүйн нас (15-49 нас)-ны 1000 эмэгтэйд ногдох тухайн жилд амьд төрсөн хүүхдийн тоог тухайн жилийн төрөх насны буюу 15-49 насны эмэгтэйчүүдийн тоонд харьцуулж, илэрхийлнэ.



ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн нийт хүн ам 2024 онд 133044 болж, өмнөх оноос 3236 (2.4%) хүнээр буурсан.

Дүүргийн хэмжээнд 2024 онд 2317 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оноос 323 (12.2%) хүүхдээр буурсан үзүүлэлтэй байна.

Хүснэгт 1. МОНГОЛ УЛС, НИЙСЛЭЛ ХОТЫН ХҮН АМЫН ТОО, дүүргээр, оноор

Засаг захиргаа	2019	2020	2021	2022	2023	2024
Монгол Улсын нийт хүн ам	3 197 020	3 357 542	3 409 939	3 368 632	3 396 788	3 441 598
Нийслэлийн дүн	1 466 125	1 597 290	1 539 252	1 596 335	1 640 781	1 677 872
Чингэлтэй	148 977	151 203	150 548	144 249	136 280	133 044
Багануур	28 570	29 342	29 433	29 341	28 926	29 152
Багахангай	4 123	4 463	4 459	4 416	4 422	4 549
Баянгол	225 840	231 517	236 385	246 886	252 979	259 411
Баянзүрх	361 689	367 679	383 892	408 797	436 822	450 873
Налайх	37 659	38 690	38 929	39 579	40 238	40 674
Сонгиохайрхан	327 580	335 703	341 540	342 112	341 390	343 439
Сүхбаатар	144 409	144 616	144 542	142 444	141 537	143 332
Хан-Уул	187 278	195 927	209 524	238 511	258 187	273 398

Чингэлтэй дүүрэгт Нийслэл хотын хүн амын 7.9 хувь, Монгол Улсын хүн амын 3.9 хувь нь байнга оршин сууж байна. Дүүргийн нутаг дэвсгэрийн нийт хэмжээ 9.1 мянган га байна.

2024 онд хүн амын дундаж наслалт монгол эрчүүд 71.8, эмэгтэйчүүдийн

дундаж наслалт 77.1 байгаа нь эрэгтэй хүний дундаж наснаас 5.3 насаар өндөр байна. Суурин хүн ам гэдэг нь тухайн нутаг дэвсгэрт 183 хоног, түүнээс дээш хугацаагаар байнга оршин сууж буй хүн ам юм.



Хүснэгт 2.


ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО, хороогоор, оноор

Хороо	2019	2020	2021	2022	2023	2024
Дүүргийн дүн	148 977	151 203	150 548	144 249	136 280	133 044
1 -р хороо	3 836	4 113	4 040	3 804	3 604	3 560
2 -р хороо	3 597	3 553	3 636	3 399	3 384	3 310
3 -р хороо	6 274	6 273	6 432	6 121	5 812	5 644
4 -р хороо	4 951	4 981	5 258	5 300	4 935	4 936
5 -р хороо	4 743	4 825	4 709	4 626	4 735	4 617
6 -р хороо	8 395	8 320	8 761	9 254	9 020	9 119
7 -р хороо	11 917	12 324	12 460	6 611	6 018	5 935
8 -р хороо	3 882	3 896	3 849	3 658	3 341	3 160
9 -р хороо	6 413	6 607	6 647	6 244	5 580	5 310
10 -р хороо	7 341	7 541	7 433	7 074	7 226	7 295
11 -р хороо	5 377	5 343	5 164	4 863	4 417	4 337
12 -р хороо	14 314	14 638	14 531	6 729	5 713	5 592
13 -р хороо	7 670	7 676	7 446	6 983	6 497	6 466
14 -р хороо	6 850	6 985	6 860	6 461	5 827	5 492
15 -р хороо	8 532	8 658	8 651	8 524	7 683	7 552
16 -р хороо	12 655	12 760	12 356	7 808	7 647	7 515
17 -р хороо	13 299	13 444	13 278	7 907	7 822	7 645
18 -р хороо	8 300	8 501	8 320	7 865	7 366	6 566
19 -р хороо	10 631	10 765	10 717	7 456	6 954	6 718
20-р хороо	-	-	-	5 223	4 772	4 629
21-р хороо	-	-	-	7 027	6 878	6 960
22 -р хороо	-	-	-	4 021	4 077	4 038
23 -р хороо	-	-	-	4 509	4 302	4 061
24 -р хороо	-	-	-	2 782	2 670	2 587

Хүн амын тооны дундаж 5542.3 байгаа бол хамгийн их хүн амтай 6 дугаар хороонд 9119 хүн байнга оршин сууж байгаа нь дүүргийн нийт хүн амын 6.9 хувийг эзэлж байна.


Зураг 1.

Хороодын хүн амын тоо, хороогоор, 2024 он



Сүүлийн жилүүдэд Нийслэлийн хэмжээнд орон сууцны хороолол, хотхон ихээр баригдаж байгаа боловч Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт томоохон орон сууцны хороолол, хотхон баригдахгүй, дахин төлөвлөлт хэд хэдэн хороон дээр хийгдэж байгаа нь хүн амын өсөлтийн хурд саарахад голлон нөлөөлж байна.

Зураг 2. ХҮН АМЫН ТОО, жилийн дундаж өсөлт, оноор



Дүүргийн нийт хүн амын 66812 буюу 49.0 хувь нь эрэгтэй, 69459 буюу 51.0 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 3. ХОРООДЫН ХҮН АМЫН ТОО, хүн ам зүй ачаалал, хороогоор, 2024 он

Хороод	Нийт хүн ам	Хүн ам зүйн ачаалал	
		Эрэгтэй	Эмэгтэй
Дүүргийн дүн	133 044	65 146	67 898
1 -р хороо	3 560	1 596	1 964
2 -р хороо	3 310	1 510	1 800
3 -р хороо	5 644	2 547	3 097
4 -р хороо	4 936	2 231	2 705
5 -р хороо	4 617	2 173	2 444
6 -р хороо	9 119	4 241	4 878
7 -р хороо	5 935	2 943	2 992
8 -р хороо	3 160	1 571	1 589
9 -р хороо	5 310	2 652	2 658
10 -р хороо	7 295	3 584	3 711
11 -р хороо	4 337	2 204	2 133
12 -р хороо	5 592	2 831	2 761
13 -р хороо	6 466	3 142	3 324
14 -р хороо	5 492	2 752	2 740
15 -р хороо	7 552	3 718	3 834
16 -р хороо	7 515	3 774	3 741
17 -р хороо	7 645	3 845	3 800
18 -р хороо	6 566	32 81	3 285
19 -р хороо	6 718	3 396	3 322
20 -р хороо	4 629	2 310	2 319
21 -р хороо	6 960	3 447	3 513
22 -р хороо	4 038	2 049	1 989
23 -р хороо	4 061	2 060	2 001
24 -р хороо	2 587	1 289	1 298

Хүн ам зүйн ачаалал 2024 онд 57.5 болсон байна. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн тутамд 50 хүүхэд, 7 өндөр настан ногдож байгааг харуулж байна. Уг үзүүлэлтийг хорооны түвшинд авч үзвэл 2 дугаар хороонд хамгийн өндөр буюу 67.4 хувь, байна. Дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6 хороод нь Нийслэл хотын төв хэсэгт байрладаг бөгөөд хүн ам зүйн ачааллын хувьд өндөр үзүүлэлттэй гарсан байна. Энэ нь орон сууцны хороодод Нийслэл хотын анхны орон сууцны барилгууд байрладаг ба

өндөр настнууд байрандаа тогтвортой амьдардаг нь нөлөөлөхөөс гадна сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ муу, хотын төвийн сургуульд хүүхдээ сургах гэсэн иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой.

Ердийн цэвэр өсөлтийн коэффициент 12.6 промил байгаа нь 1000 хүн ам тутмын 12 нь шинээр мэндэлсэн хүүхэд байна.

Хүснэгт 4.

ХҮН АМЫН ЕРДИЙН БОЛОН МЕХАНИК ӨСӨЛТ, өсөлтийн коэффициент, оноор

Он	Төрөлт	Нас баралт	Ердийн цэвэр өсөлт	Ердийн цэвэр өсөлтийн коэффициент	Шилжин ирсэн	Шилжин явсан	Механик өсөлт	Шилжих хөдөлгөөний цэвэр өсөлтийн коэффициент
2019	3 863	896	2 967	17.6	9 235	-	-	-
2020	3 591	821	2 770	18.4	7 447	-	-	-
2021	3 358	1 195	2 163	14.3	7 056	-	-	-
2022	2 876	983	1 893	16.0	2 484	-	-	-
2023	2 640	921	1 719	12.6	1 742	-	-	-
2024	2 317	997	1 320	26.7	1 310	-	-	-

2024 онд төрөлт 2317 болж өмнөх оны мөн үеэс 323 (12.2%) буурсан бол, нас баралт 997 бүртгэгдэж өмнөх оноос 76 (8.3%) өссөн үзүүлэлтэй байна.



Хүснэгт 5.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН СУУРИН ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр,

Насны ангилал	2021		2022		2023		2024	
	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй
Нийт дүн	150 548	77 198	144 249	73 837	136 280	69 459	133 044	67 898
0 нас	3 125	1 653	2 620	1 261	2 237	1 081	2 024	1 023
1-4	13 231	6 805	12 001	5 857	10 593	5 130	9 426	4 529
5-9 нас	17 606	9 016	16 251	7 902	14 700	7 117	13 866	6 744
10-14 нас	14 116	6 891	14 214	6 931	14 000	6 857	14 013	6 864
15-19 нас	8 927	4 335	9 213	4 459	9 550	4 610	10 369	5 011
20-24 нас	9 274	4 723	8 854	4 405	8 120	3 937	7 884	3 827
25-29 нас	10 046	5 092	9 110	4 565	8 426	4 164	8 046	3 932
30-34 нас	14 199	7 105	12 861	6 439	10 798	5 326	9 599	4 736
35-39 нас	12 179	6 167	11 795	5 877	11 389	5 594	11 223	5 525
40-44 нас	10 211	5 212	9 890	5 056	9 446	4 804	9 468	4 777
45-49 нас	9 294	4 935	8 968	4 740	8 612	4 545	8 432	4 406
50-54 нас	7 975	4 271	7 855	4 210	7 647	4 107	7 555	4 071
55-59 нас	7 190	4 027	7 004	3 938	6 843	3 769	6 721	3 733
60-64 нас	5 543	3 221	5 682	3 279	5 688	3 295	5 798	3 348
65-69 нас	3 277	1 981	3 475	2 103	3 676	2 243	3 897	2 362
70, түүнээс дээш нас	4 355	2 750	4 456	2 815	4 555	2 880	4 723	3 010

Чингэлтэй дүүргийн нийт хүн амын 10066 (7.6%) нь цэцэрлэгийн насны хүүхэд байгаа бол эдгээр хүүхдийн 8861 (88.0%) нь цэцэрлэгт хамрагдаж байна. Харин нийт хүн амын 33908 (25.5%) нь сургуулийн насны хүүхэд байгаагаас 29432 (86.8%) хувь нь сургуульд хамрагдаж байна. Тэтгэврийн насны хүний тоо 18151 болж өмнөх оны мөн үеэс 873 (5.1%) буурсан байна.

Хүснэгт 6.


ДҮҮРГИЙН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ АНГИЛАЛ, хороогоор, 2024 он

Хороо	Цэцэрлэгийн насны хүүхэд (2-5 нас)		Сургуулийн насны хүүхэд (6-18 нас)		Өндөр настан (эр-60+, эм-55+)	
	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй	нийт	эмэгтэй
Дүүргийн дүн	10 066	4 852	33 908	16 470	18 151	12 453
1-р хороо	226	104	996	484	601	422
2-р хороо	214	116	943	445	523	373
3-р хороо	361	165	1 566	767	944	640
4-р хороо	316	148	1 219	611	838	590
5-р хороо	300	168	1 076	527	811	576
6-р хороо	706	316	2 542	1 234	1 174	829
7-р хороо	505	267	1 405	684	745	508
8-р хороо	239	122	692	339	497	329
9-р хороо	396	192	1 264	625	762	532
10-р хороо	618	290	1 893	933	836	583
11-р хороо	292	142	1 069	496	602	407
12-р хороо	386	170	1 390	677	801	536
13-р хороо	517	271	1 628	791	903	614
14-р хороо	428	208	1 306	614	797	541
15-р хороо	603	298	1 970	972	932	642
16-р хороо	620	296	1 896	886	961	650
17-р хороо	559	258	1 933	954	1 044	708
18-р хороо	444	202	1 640	799	863	598
19-р хороо	508	241	1 762	836	866	571
20-р хороо	370	178	1 179	570	483	334
21-р хороо	651	321	1 813	894	664	463
22-р хороо	329	147	1 041	520	453	311
23-р хороо	315	154	1 060	504	520	357
24-р хороо	163	78	625	308	531	339

➤ ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД

Нийгмийн зарим үзүүлэлтийн судалгаагаар 2024 онд бүтэн өнчин 97 хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 27 (21.8%) хүүхдээр буурсан үзүүлэлтэй байна. Бүтэн өнчин хүүхдийн 53 (54.6%) нь эмэгтэй хүүхэд байна.

2024 онд хагас өнчин 1682 хүүхэд бүртгэгдсэн нь өмнөх оноос 52 (3.0%) хүүхдээр буурсан байна. Дүүргийн 0-17 насны нийт хүүхдийн 3.6 хувь нь хагас өнчин хүүхэд байна. Үүнээс 826 (49.1%) нь эмэгтэй хүүхэд байна.

Зураг 4.**ХАГАС, БҮТЭН ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО, ОНООР**

➤ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮН АМ

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 3316 болж өмнөх оны мөн үеэс 747 (18.4%) хүнээр буурсан байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 1428 (43.1%) нь эмэгтэйчүүд, 455 (13.7%) нь 0-17 насны хүүхэд, 108 (3.3%) нь 65 түүнээс дээш насны хүн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй болсон шалтгаанаар авч үзвэл 1681 буюу 50.7 хувь нь төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй, 1626 буюу 49.0 хувь нь олдмол өвчнөөр, 52 буюу 1.5 хувь нь осол гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон байна.

Дүүргийн 0-17 насны хүүхдийн 497 (15.0%) нь хөгжлийн бэрхшээлтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг өвчний

төрлөөр авч үзвэл 309 (9.3%) нь харах эрхтний өөрчлөлттэй, 194 (5.9%) нь сонсголын бэрхшээлтэй, 133 (4.0%) нь ярианы бэрхшээлтэй, 588 (17.7%) нь хөдөлгөөний бэрхшээлтэй, 731 (22.0%) нь сэтгэцийн эмгэгтэй, 319 (9.6%) нь хавсарсан согогтой, 1033 (31.2%) нь бусад өвчний төрөлд хамрагдаж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 1527 (46.2%) нь нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон ахмад настан, 1466 (35.8%) нь байнгын асаргаанд байдаг иргэд тус тус байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 0-17 насны 402 хүүхэд байна.

Хүснэгт 9.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо, өвчний төрөл, насны бүлгээр, 2024

Үзүүлэлт	Хөгжлийн бэрхшээлийн төрөл									
	Бүгд	Эмэгтэй	Хөдөлмөр эрхэлдэг	Төрөлхийн	Олдмол	Өвчнөөр		Осол гэмтлээр		
						Ердийн өвчин	Мэргэжлээс шалтгаалсан өвчин	Зам тээврийн осол	Үйлдвэрлэлийн осол	Ахуйн осол
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	3 307	1 492	249	1 681	1 626	1 409	44	52	38	108
0-4 нас	72	26	1	64	8	7	-	-	-	1
5-9 нас	174	54	-	145	29	27	-	-	-	2
10-14 нас	189	86	-	150	39	37	-	-	-	2
15 нас	35	16	-	20	15	15	-	-	-	-
16 нас	24	13	1	21	3	2	-	-	-	1
17 нас	26	11	-	15	11	10	-	-	-	1
18 нас	16	8	-	12	4	4	-	-	-	-
19 нас	18	9	-	12	6	5	-	-	1	-
20-34 нас	496	240	47	310	186	161	4	7	2	12
35-64 нас	2 058	889	197	893	1165	985	39	44	35	62
65, түүнээс дээш нас	199	140	3	39	160	156	1	1	-	2

Ойлголт, тодорхойлолт

Хүн амын бүртгэл: Тухайн газар нутагт тодорхой цаг хугацааны дотор гарсан хүн ам зүйн үзэгдэл болон хүн амын тоог бүртгэж авах үйл явц болно.¹

Хүн амын ердийн хөдөлгөөний статистик: Хүн амын ердийн хөдөлгөөнтэй холбоотой бүх үзэгдэл, тухайлбал төрөлт, нас баралт, шилжин ирэгчид болон шилжин явагчдын тоо, гэрлэлт, гэр бүл салалтын тоо, тэдгээрийг үндэслэн тооцдог харьцуулсан үзүүлэлтүүдээс бүрдэнэ.¹

Хүн ам зүйн шилжилт: Хүн амын төрөлт болон нас баралтын өндөр түвшинээс нам түвшинд шилжиж буй динамик шилжилт юм. Нас баралтын бууралт нь голдуу төрөлтийн бууралтаас түрүүлж явагддаг бөгөөд энэ нь шилжилтийн хугацааны туршид хүн амын огцом өсөлтийг бий болгодог.¹

Хүн амын тоо: Тодорхой хугацаанд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ. Хүн амын тоог бэлэн болон суурин хүн амаар тооцдог.¹

Суурин хүн ам: Тухайн засаг захиргааны нэгжид 183 хоног буюу 6 сараас дээш хугацаагаар оршин сууж байгаа хүн амыг хэлнэ.²

Бэлэн хүн ам: Тооллого явуулж буй үед тухайн нутагт дэвсгэрт оршин сууж байгаа нийт хүн амыг (байнга болон түр хугацаагаар амьдарч байгаагаас үл хамаарч) хэлнэ. Бэлэн хүн амыг хүн ам, орон сууцны тооллогоор 10 жилд нэг удаа тодорхойлно.²

Жилийн эхний хүн ам: Тайлант оны эхэнд, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.²

Жилийн эцсийн хүн ам: Тайлант оны эцэст, тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа хүн амын тоог илэрхийлнэ.²

$$P(n) = P_0 + (B - D) + (In - Out)$$

P(n)-	Хугацааны эцэс дэх хүн амын тоо
P ₀ -	Оны эхний хүн ам
B-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх нийт төрөлт
D-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх нийт нас баралт
In-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжин ирэлт
Out-	Хугацааны эхнээс эцэс хүртэлх шилжин явалт

Хүн амын жилийн дундаж тоо: Тайлант оны эхний болон эцсийн хүн амын тооны дунджаар илэрхийлэгдэнэ.²

$$XA_{(дун)} = \frac{XA_{(ж.эх)} + XA_{(ж.эц)}}{2}$$

$XA_{(дун)}$ - Хүн амын жилийн дундаж тоо

$XA_{(ж.эх)}$ - Жилийн эхний хүн амын тоо

$XA_{(ж.эц)}$ - Жилийн эцсийн хүн амын тоо

Хүн амын өсөлт, бууралт: Тодорхой хугацааны туршид хүн амын тооны эерэг өөрчлөлтийг хүн амын өсөлт, сөрөг өөрчлөлтийг хүн амын бууралт гэнэ.³

Хүн амын ердийн цэвэр өсөлт, бууралт: Тухайн жилийн хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр илэрхийлэгдэнэ.³

Тооцох арга зүй: Тухайн онд төрсөн нийт хүүхдийн тооноос нас барсан нийт хүний тоог хасч тооцно. Төрөлт, нас баралтын тооноос шалтгаалж энэ үзүүлэлт нь эерэг, сөрөг аль нь ч байж болно.

$$E\Theta_{(XA)} = TT - HBT$$

$E\Theta_{(XA)}$ - Хүн амын ердийн цэвэр өсөлт

TT - Төрсөн нийт хүүхдийн тоо

HBT - Нас барсан нийт хүний тоо

Хүн амын ердийн цэвэр өсөлт (бууралт)-ийн коэффициент: Хүн амын төрөлт, нас баралтын тооны зөрүүгээр тухайн жилийн хүн ам өссөн (буурсан)-ийг харуулах коэффициент бөгөөд түүнийг суурин хүн амд эзлэх хувиар илэрхийлнэ.¹

Тооцох арга зүй: Тухайн онд төрсөн нийт хүүхдийн тооноос нас барсан нийт хүний тоог хасч, хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ. Төрөлт, нас баралтын тооноос шалтгаалж энэ үзүүлэлт нь эерэг, сөрөг аль нь ч байж болно.

$$E\Theta K_{(XA)} = \frac{TT - HBT}{XA_{(дун)}} * 1000$$

$E\Theta K_{(XA)}$ - Хүн амын ердийн цэвэр өсөлт /бууралтын коэффициент

TT - Төрсөн нийт хүүхдийн тоо

HBT - Нас барсан нийт хүний

тоо $XA_{(дун)}$ - Хүн амын жилийн


дундаж тоо

ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийслэлийн Чингэлтэй дүүрэгт 2024 онд өрхийн тоо 36857 болж өмнөх оны мөн үеэс 879 (2.4%) буурсан байна. Чингэлтэй дүүрэгт Монгол Улсын нийт өрхийн 3.7 хувь, Нийслэл хотын нийт өрхийн 7.8 хувь нь байнга оршин сууж байна.

Хүснэгт 10. МОНГОЛ УЛС, НИЙСЛЭЛ ХОТЫН ӨРХИЙН ТОО, ДҮҮРГЭЭР, ОНООР

Захиргаа	2019	2020	2021	2022	2023	2024
Монгол Улсын нийт өрх	897 427	908 712	920 165	941 548	983 485	997 023
Нийслэлийн дүн	411 420	414 292	412 527	431 000	465 059	475 117
Чингэлтэй	39 345	39 113	38 413	37 249	37 736	36 857
Багануур	8 133	8 328	8 557	8 662	8 880	8 952
Багахангай	1 131	1 185	1 222	1 230	1 298	1 293
Баянгол	62 976	63 079	62 784	65 543	69 519	71 371
Баянзүрх	104 764	105 791	104 881	113 245	128 009	131 827
Налайх	10 248	10 388	10 263	10 510	10 838	10 991
Сонгиохайрхан	93 521	94 132	90 231	91 815	95 895	96 524
Сүхбаатар	40 061	39 507	39 302	38 782	39 984	40 445
Хан-Уул	51 241	52 769	56 874	63 967	72 900	76 857





Хүснэгт 11.

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ӨРХИЙН ТОО, хороогоор, оноор


Захиргаа	2019	2020	2021	2022	2023	2024
Дүүргийн дүн	39 345	39 113	38 413	37 246	37 736	36 857
1 -р хороо	922	921	909	881	864	855
2 -р хороо	993	975	962	940	969	955
3 -р хороо	1 669	1 661	1 599	1 571	1 602	1 566
4 -р хороо	1 305	1 275	1 253	1 246	1 265	1 256
5 -р хороо	1 221	1 209	1 187	1 164	1 221	1 206
6 -р хороо	2 314	2 310	2 322	2 367	2 510	2 515
7 -р хороо	3 250	3 250	3 268	1 757	1 758	1 761
8 -р хороо	1 068	1 034	983	940	958	916
9 -р хороо	1 778	1 716	1 689	1 594	1 554	1 504
10 -р хороо	1 694	1 762	1 810	1 717	1 920	1 946
11 -р хороо	1 358	1 344	1 325	1 249	1 226	1 203
12 -р хороо	3 523	3 495	3 480	1 627	1 598	1 554
13 -р хороо	1 961	1 936	1 870	1 761	1 768	1 732
14 -р хороо	1 781	1 810	1 769	1 674	1 618	1 526
15 -р хороо	2 207	2 205	2 143	2 094	2 125	2 041
16 -р хороо	3 291	3 274	3 067	1 979	1 980	1 959
17 -р хороо	3 640	3 563	3 543	2 131	2 214	2 154
18 -р хороо	2 419	2 427	2 325	2 220	2 230	2 010
19 -р хороо	2 951	2 946	2 915	2 014	1 972	1 919
20-р хороо	-	-	-	1 392	1 320	1 277
21-р хороо	-	-	-	1 728	1 782	1 804
22-р хороо	-	-	-	1 039	1 122	1 105
23 -р хороо	-	-	-	1 263	1 249	1 199
24 -р хороо	-	-	-	898	911	889

Гэрлэлтээ бүртгүүлсэн хүний тоо 2024 онд 625 болж өмнөх оноос 248 (39.7%) хүнээр буурсан байна. Шинээр гэр бүлээ бүртгүүлсэн хос 618 (98.9%) байна. Үүнээс 7 (1.1%) нь гэрлэлтээ дахин сэргээсэн хос байна.

Гэрлэлтээ батлуулсан хүний 46.9 хувь нь 25-34 настай, 46.4 хувь нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд байна.

Зураг 6.

ГЭРЛЭСЭН ХОС, БОЛОВСРОЛЫН, түвшнээр




Зураг 7.**Гэрлэлтээ цуцалсан хос, хамт амьдарсан жилээр, хувиар**

Шүүхийн шийдвэрээр 286 хос гэрлэлтээ цуцлуулсан нь өмнөх оноос 46 буюу (13.9%) буурсан байна. Гэрлэлтээ цуцлуулсан хосын 35.0 хувь нь 30-39 настай, 14.4 хувь нь 10-14 жил хамт амьдарсан, 48.3 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд байна.

Өндөр настай ганц бие өрх 2024 оны жилийн эцсийн байдлаар 765 болж өмнөх оны мөн үеэс 151 (16.5%) буурсан байна. 18 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 992 бүртгэгдэж өмнөх оноос 768 (43.6%) өрхөөр буурсан байна.

Дүүргийн нийт өрхийг сууцны төрлөөр нь авч үзвэл 8770 өрх буюу 23.8 хувь нь нийтийн орон сууцанд, 351 өрх буюу 1.0 хувь нь бие даасан тохилог



сууцанд, 18853 өрх буюу 51.2 хувь нь сууцны тусдаа байшинд, 8865 өрх буюу 24.1 хувь нь монгол гэрт амьдарч байгаа бол 18 өрх буюу 0.04 хувь нь өөрсдийн гэсэн орон гэргүй амьдарч байна.

**Хүснэгт 12.** ӨРХИЙН ТОО, СУУЦНЫ ТӨРЛӨӨР, хороогоор, 2024 он

Захиргаа	Нийт өрхийн тоо	Нийтийн орон сууцанд амьдардаг	Тусдаа тохилог орон сууц амьдардаг	Байшинд амьдардаг	Монгол гэрт амьдардаг	Орон гэргүй /тэнэмэл/
Дүүргийн дүн	36 857	8 770	351	18 853	8 865	18
1 -р хороо	855	850	5	-	-	-
2 -р хороо	955	955	-	-	-	-
3 -р хороо	1 566	1 566	-	-	-	-
4 -р хороо	1 256	1 254	2	-	-	-
5 -р хороо	1 206	1 205	1	-	-	-
6 -р хороо	2 515	2 515	-	-	-	-
Байшин хорооллын дүн	8 353	8 345	8	-	-	-
7 -р хороо	1 761	-	42	1 171	547	1
8 -р хороо	916	-	-	752	159	5
9 -р хороо	1 504	-	80	1 188	236	-
10 -р хороо	1 946	341	-	766	839	-
11 -р хороо	1 208	-	11	816	380	1
12 -р хороо	1 554	-	-	1 098	452	4
13 -р хороо	1 732	7	18	1 383	324	-
14 -р хороо	1 526	-	18	1 072	436	-
15 -р хороо	2 041	49	-	1 626	366	-
16 -р хороо	1 959	-	-	1 396	563	-
17 -р хороо	2 154	-	27	1 585	541	1
18 -р хороо	2 010	-	3	1 210	797	-
19 -р хороо	1 919	-	16	1 303	600	-
20-р хороо	1 277	-	31	674	569	3
21-р хороо	1 804	28	56	888	831	-
22-р хороо	1 105	-	1	685	420	-
23-р хороо	1 199	-	20	644	534	1
24-р хороо	889	-	20	596	271	2
Гэр хорооллын дүн	28 504	425	343	18 853	8 865	

Ойлголт, тодорхойлолт

Өрх: Ганц бие болон нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг өрх гэнэ. Өрхийн гишүүд нь хоорондоо ураг төрлийн холбоотой, хамаатан садан, зарим гишүүд нь огт хамааралгүй, эсвэл эдгээрийн аль алинаас бүрдсэн байж болно. Өрх гэдэг нь гэр бүл гэсэн ойлголтоос ялгаатай. Нэг өрхөд нэг болон хэд хэдэн гэр бүл амьдарч байж болно.⁶

Өрхийн тэргүүн: Өрхийн гишүүд хэнийгээ тэргүүлэгч гэхийг сайн дураар шийдвэрлэнэ. Гэхдээ өрхийн тэргүүлэгч нь өрхдөө байнга оршин суугч, 16-гаас дээш насны бөгөөд өрхийн бусад гишүүд өрхийн тэргүүлэгчээр өргөмжилсөн хүн байна. Хэрвээ өрхийн тэргүүлэгчээ тодорхойлж чадахгүй бол тухайн өрхийн орлогын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа хүнийг өрхийн тэргүүнээр авч үзэж болно.⁶

Өрхийн ам бүлийн гишүүд: Ураг төрлийн болон гэр бүлийн холбоотой болон холбоогүй, нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын бусад хэрэгцээгээ хамтран хангадаг нэг буюу хэсэг хүмүүсийг тухайн өрхийн ам бүлийн гишүүн гэж үзнэ. Гэхдээ тухайн өрх айлд өрхийн ам бүлийн гишүүдээс нь гадна түүнд хамрахгүй садан төрөл, бусад хүмүүс амьдарч болно. Түүнээс гадна өөр газар амьдарч, ажиллаж (хугацаат цэргийн алба хааж байгаа, өөр аймаг, нийслэлд сурч байгаа оюутан сурагчид, түр хугацаагаар гадаад, дотоодод явагчид гэх мэт) байгаа өрхийн ам бүлийн гишүүд орно.⁶

Өрхийн ам бүлийн дундаж тоо: Нэг өрхөд ногдох өрхөд харьяалагдан амьдардаг хүний тоог илэрхийлнэ.³

Гэр бүл: Голдуу гэрлэлт, төрөлт эсвэл үрчлэлтээр холбогдон хамтдаа амьдарч буй хоёр ба түүнээс олон тооны хүнийг хэлнэ. Гэр бүл нь төрсөн ах, эгч, дүүс, ураг төрлийн бусад холбоотой хүмүүс, гэр бүл тэдгээрийн үр хүүхдээс бүрдэж болно.³

Гэрлэлтийн байдал: Гэр бүлийн тухай Монгол Улсын хууль болон уламжлалт ёсны дагуу гэрлэлтийн байдлыг дараахь төрлүүдээр тодорхойлно.³

Огт гэр бүл болоогүй: Арван тав, түүнээс дээш настай, огт гэрлэж байгаагүй хүнийг энд хамруулна.

Гэрлэсэн гэдэгт дараахь хүн амыг хамруулна.

I. **Батлуулсан гэр бүлтэй:** Гэрлэлтээ иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлсэн, гэрлэлтийн баталгаатай хүмүүсийг хэлнэ.

II. **Батлуулаагүй гэр бүлтэй:** Гэр бүл болж хамтран амьдарч байгаа боловч (хугацаа харгалзахгүйгээр) иргэний гэр бүлийн байгууллагад бүртгүүлж, гэр бүлээ батлуулаагүй хүмүүсийг хэлнэ.

Бэлбэсэн: Эхнэр, нөхрийн аль нэг нь нас барснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй бол бэлбэсэн гэж үзнэ.

Тусгаарласан: Гэр бүлээ албан ёсоор цуцлуулаагүй, тусдаа амьдарч байгаа хүмүүсийг тусгаарласан гэж үзнэ.

Цуцалсан: Гэр бүлээ хуулийн дагуу цуцалснаас хойших хугацааг харгалзахгүйгээр дахин гэрлээгүй байгаа хүмүүсийг гэр бүлээ цуцалж салсан гэж үзнэ.

Гэрлэлтийн голч нас: Нийт гэрлэсэн хүн амын тоог анх гэрлэсэн насаар нь таллан хуваах үеийн нас болно. Энэ нь тухайн онд гэрлэсэн хүн амын тал хувь нь голч наснаас өмнөх насандаа, үлдсэн тал хувь

нь түүнээс хойших насандаа гэрлэж байгааг харуулна.^{1,5}

Гэрлэлтийн дундаж нас: Тухайн улсын хүн ам төрснөөсөө хойш дунджаар хэдэн жилийн дараа гэрлэж байгааг харуулна.^{1,5}

Тооцох арга зүй: Насны бүлэг дэх гэрлэсэн хүн амын тоог гэрлэх үеийн насны бүлгийн дундаж утгаар үржүүлж, нийлбэрийг гэрлэгчдийн нийт тоонд харьцуулж тооцно.

$$ГДН = \frac{\sum(\tilde{A}_i * НБД_i)}{ГТ}$$

ГДН - Гэрлэлтийн дундаж нас

$\tilde{A}_i$ - i насны бүлгийн гэрлэсэн хүн амын тоо

НБД _{i} - i гэрлэх үеийн насны бүлгийн дундаж утга

ГТ - Гэрлэгчдийн нийт тоо

Гэрлэлтийн ерөнхий коэффициент: Тухайн жилийн 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.^{1,5}

Тооцох арга зүй: Тухайн жилийн гэрлэлтийн нийт тоог (анхны болон дахин гэрлэлт орсон) хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ.

$$ГЕК = \frac{ГТ}{ХА(дун) * 1000}$$

ГЕК - Гэрлэлтийн ерөнхий коэффициент

ГТ - Тухайн жилийн гэрлэлтийн нийт

тоо $ХА(дун)$ - Хүн амын жилийн дундаж

тоо

Гэрлэлтийн тусгай коэффициент: Тухайн жилийн 15 ба түүнээс дээш насны 1000 хүн тутамд ногдох гэрлэлтийн тоог илэрхийлнэ.^{1,5}

Тооцох арга зүй: Тухайн жилийн гэрлэлтийн нийт тоог 15 буюу түүнээс дээш насны хүн амын тоонд харьцуулж, 1000-аар үржүүлнэ.

$$ГТК = \frac{ГТ}{ХА(15+) * 1000}$$

ГТК - Гэрлэлтийн тусгай коэффициент

ГТ - Тухайн жилийн гэрлэлтийн нийт

тоо $ХА(15+)$ - 15 ба түүнээс дээш насны

хүн амын тоо



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН

Хайх ...



СТАТИСТИКИЙН мэдээллээ аваарай

Data lab

тооллого судалгааны
микро мэдээллийн сан



Social network



/StatisticMGL

Лавлах утас



1900-1212

Цахим шуудан



information@nso.mn

Танилцуулга хянасан:

Д.МӨНХЗУЛ

Танилцуулгыг боловсруулан:

Г.ПҮРЭВСҮРЭН